**<u>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:</u>**
***“ЭРДЭС ГРУПП” ХХК***

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ТӨМӨРТЭЙН ОРДЫН ТӨМӨРИЙН ХҮДРИЙН “ТӨМӨРТЭЙН ГОЛ” УУРХАЙ /MV-011426A/

/2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт/

**2023он**

## АГУУЛГА

АГУУЛГА ... 1
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ ... 2
“ЭРДЭС ГРУПП” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 4
ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ ... 5
ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ... 9
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ...
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 13
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 22
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 23
ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 26
ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 28
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 33
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ... 39
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 46
ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ... 48
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 48
ДҮГНЭЛТ ... 49

## ***ХАВСРАЛТ МАТЕРИАЛ***

- Эмнэлэгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах аюулгүй болгох гэрээ
- Хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ
- Хог хаягдлын гэрээ
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн /агаарын шинжилгээний дүн/
- Шинжлэх ухааны акдеми газар зүй-геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лаборатори / усны химийн шинжилгээний тодорхойлолт/
- Ус цаг уур, орчны шинжилгээний төв /Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/
- Ойжуулалтын акт
- Нөхөн сэргээлтийн баталгаа
- ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал , тэмдэглэл

# ОРШИЛ

“Эрдэс групп” ХХК-ний “Төмөртэйн гол” уурхайн баяжуулах үйлдвэр нь 2008 оноос эхлэн өнөөдрийг хүртэл ажиллах хугацаандаа уулын цул 4692,6 мян.$м^3$ үүнээс: 4432,3 мян.$м^3$ буюу 1007,2 мян.тн хүдэр олборлосон.

2023 онд төлөвлөгөөний дагуу 4-р сараас үйл ажиллагаагаа эхлүүлэхээр батлуулсан хэдий ч эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт санхүүгийн хүндрэлээс шалтгаалан “Төмөртэйн гол” УБҮ бүрэн хүчин чадлаараа төлөвлөсөн хугацаандаа ажиллаж чадаагүй.

2023 онд уулын олборлолтын үйл ажиллагаа явагдаагүй. Баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаар 20 хоног ажиллаж, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн засвар, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэн 2022 онд олборлосон 89.4 мян.тн хүдрээс 66.2 мян.тн хүдрийг хуурай соронзон сеперацийн аргаар боловсруулж 39.7 мян.тн төмрийн бүхэллэг баяжмал үйлдвэрлэн гаргасан. Тус онд төмөр замын тээврээс шалтгаалан баяжмал борлуулалтын ажил хийгдээгүй болно.

“Эрдэс групп” ХХК-ний “Төмөртэйн гол” уурхай нь ашигт малтмалын ордын тогтоцын онцлогоос хамаарч 2023 онд АМГТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 5-р сард уурхайд ирж ажилласан. Ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу ажлуудыг 2023 оны БОМТ-д тусгаж хэрэгжүүлэн ажилласан.

## ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Физик газарзүй, эдийн засгийн товч тодорхойлолт**

Тус орд нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Улаанбаатар хотоос хойт зүгт 360 км, Дархан хотоос зүүн хойш 140 км, Хүдэр сумаас баруун урагшаа 32 км зайд оршдог.

***Номенклатур:*** М-48-83

***Газарзүйн солбицол:*** Өргөрөг $49^{0}\ 40^{I}\ 15^{II}$ - $49^{0}\ 40^{I}\ 54^{II}$

Уртраг $107^{0}\ 12^{I}\ 30^{II}$ - $107^{0}\ 15^{I}\ 00^{II}$

***Засаг захиргаа***: Сэлэнгэ аймгийн Хүдэр сум

Төслийн талбайн байршлын тойм зураг



“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль 2015 оны 2 дугаар сарын 18- ны өдөр батлагдсанаар дахин үйл ажиллагаа явуулах эрх нь дахин бүрдээд байна. Засгийн Газрын 120-р тогтоолоор баталсан “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийх журам”-д үндэслэсэн Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 11-ний өдрийн 55 тоот шийдвэрээр “Эрдэс групп” ХХК-ийн эзэмшилд байгаа MV-011426 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон 362 га талбайн 117.55 га талбайг буцаан өгч 244,74 га талбайд үйл ажиллагаа явуулж байна.

**Төмрийн хүдрийн ордын лицензийн 244.74 га талбайн солбицлын цэгүүд**

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 107 | 13 | 46.18 | 49 | 40 | 16.96 |
| 2 | 107 | 12 | 31.32 | 49 | 40 | 16.96 |
| 3 | 107 | 12 | 31.32 | 49 | 40 | 55.96 |
| 4 | 107 | 15 | 1.31 | 49 | 40 | 55.96 |
| 5 | 107 | 14 | 57.03 | 49 | 40 | 54.93 |
| 6 | 107 | 14 | 48.04 | 49 | 40 | 53.46 |
| 7 | 107 | 14 | 46.99 | 49 | 40 | 52.98 |
| 8 | 107 | 14 | 43.61 | 49 | 40 | 50.72 |
| 9 | 107 | 14 | 41.27 | 49 | 40 | 49.99 |
| 10 | 107 | 14 | 38.73 | 49 | 40 | 49.82 |
| 11 | 107 | 14 | 35.43 | 49 | 40 | 49.3 |
| 12 | 107 | 14 | 31.34 | 49 | 40 | 49 |
| 13 | 107 | 14 | 29.01 | 49 | 40 | 46.38 |
| 14 | 107 | 14 | 24.41 | 49 | 40 | 44.58 |
| 15 | 107 | 14 | 18.21 | 49 | 40 | 43.03 |
| 16 | 107 | 14 | 12.29 | 49 | 40 | 41.02 |
| 17 | 107 | 14 | 11.55 | 49 | 40 | 38.41 |
| 18 | 107 | 14 | 6.41 | 49 | 40 | 36.27 |
| 19 | 107 | 14 | 1.17 | 49 | 40 | 32.01 |
| 20 | 107 | 13 | 57.72 | 49 | 40 | 28.92 |
| 21 | 107 | 13 | 54.04 | 49 | 40 | 25.51 |
| 22 | 107 | 13 | 51.02 | 49 | 40 | 21.54 |

***Газарзүйн тогтоц***: Хэнтийн уулархаг мужийн баруун хойд хэсэгт Ерөө ба Хүдэр голын дундах салбар уулсад хамаарна. Гадаргуугийн хувьд 1000-1250 м үнэмлэхүй өндөртэй нам уул дов толгодорхог релефьтэй, уул толгодын хажуу бэлийн налуу их ба голын хөндийгөөр эрчимтэй сархиагжсан байдаг.

***Ус цаг уур:*** Эх газрын эрс тэс уур амьсгалтай, цаг агаарын өөрчлөлт огцом, температурын хэлбэлзэл их, агаарын дулааны хамгийн өндөр хэм нь 38°C, хамгийн хүйтэн хэм нь -48°C, жилийн дундаж дулааны хэмжээ -1.9$^{0}$C, жилийн дундаж борооны хэмжээ 240 мм, цас уналтын хэмжээ 240-530 мм, газар хөлдөлтийн гүн 2.0-2.5 м.

***Гадаргын ус:*** Энэ районд ус зүйн сүлжээ сайн хөгжсөн Ордын талбайн урдуур төмөртэйн гол урсаж өнгөрдөг. Төмөртэйн гол Галттайн голд цутгана. Төмөртэйн голын гольдролын урт 15км.

Төмөртэйн голын голдрил 0,5м хүртэл өндөртэй эгц эрэгтэй . Голдрилын өргөн 1,8м, усны зузаан 0,07м , урсгалын хурд 0,16м/с өнгөрөлт 0,02 м$^3$/с.

Гольдролын ёроол элсэн чигжээстэй , хайргархаг хурдастай. Голын ус нь тунгалаг, үнэр амтгүй химийн найрлагаараа гидрокарбонатын ангийн , кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг , зөөлөн устай.

***Газар доорх ус:*** Уг талбайн геологийн тогтоц нь нүх сүвийн болон ан цавын коллектор болох чулуулаг тархсан нөхцөлийг бүрдүүлсэн. Иймээс нүх сүвийн болон ан цавын газар доорхи усны дэд төрлүүдэд хуримтлагдана. Нүх сүвийн ус агуулагч дөрөвдөгч галавын сэвсгэр хурдас нь элсэнцэр , хайрга , дайрга, бул чулуу зэргээс тогтоно.

Газар доорх ус нь 1,0м орчим гүнээс илрэх ба хур тунадасын нэвчилт , ан цавын усаар тэжээгдэнэ. Ан цавын ус агуулагч Рифей-түрүү Кембрийн настай элсэн чулуу, занар роговик, шохойн чулуу уг талбайд зонхилсон.

***Хөрс:*** Талбайн гадаргуугийн нөхцөл, зүг зовхисын ялгаа, хөрс үүсгэгч чулуулгийн төрөл, ул хөрсний усны илрэх гүн, ургамлан нөмрөгийн бүлгэмдлээс хамаарч ууланд нь уулын ойн ширэгт бараан хөрс, уулын хар шороон хөрс, уулын бэлээс доош налуувтар хажуугийн ой модтой газраар уулын ойн ширэгт нугархаг бараан хөрс, нугат хээрийнөвслөг ургамалтай хэсэгт нь нугархаг хар шороон хөрс, голын татмын хус, улиангар, торлогон бургастай доворхог газраар аллювийн нугат-намгийн цэвдэгт хөрс зэрэг хэд хэдэн хэв шинжийн хөрс тархдаг.

***Ургамал:*** Талбайн 9,23% уулын энгэр , ойн цоорхой, хормой орчмын элдэв өвс-үетэн голлосон уулын хээрийн ба нугат хээрийн өтгөн өвслөг ургамалтай. Ойн зах хормой түүнээс доош газарт элдэв –өвс , үетэн өтгөн ургасан байх бөгөөд талбайн 90,77 хувийг эзэлсэн ойд үетэн алаг өвст хусан ой , улалж бавран-алаг өвст тайгархаг хусан ой улалж алаг өвст хээрийн нарсан ойн хэв шинжүүд зонхилсон байдаг.

***Амьтан:*** Ерөө гол түүний цутгал голуудын сав, Төмөртэй орчмоор тархсан хөхтөн амьтад хөвч, холимог ой голын төгөл бургас ус, задгай тал гэсэн амьдрах орчинг даган байршина. Ерөө голын сав нутагт одоо нийтдээ 6 баг, 17 овогт хамрах 48 зүйл зэрлэг амьтан амьдардаг. Төмөртэйн орд орчимд: бараан хэрэм, урт сүүлт зурам, дагуур зараа , чандага, саарал чоно, шар үнэг, хярс , дорго, хотны үен , өмхий хүрэн, ойн солонго,бор туулай,шилүүс,нохой зээх, бор гөрөөс, халиун буга хүдэр зэрэг хөхтөн амьтан тэмдэглэгдсэн байдаг.

***Дэд бүтэц*:** Ордын талбай нь зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн Дархан – Сэлэнгийн бүс нутагт хамрагддаг бөгөөд Улаанбаатар – Дархан –Сэлэнгэ- Хүдэрийн асфалтан замтай сайжруулж зассан шороон замаар холбогддог. Төмөртэйн гол уулын баяжуулах үйлдвэр нь ашиглалт явуулахад шаардлагатай бүх барилга байгууламж, дэд бүтцийг бүрдүүлсэн ба үүнд ажилчдын хотхон ба уурхайн захиргааны цогцолбор, механик цех, хүдрийн лаборатори болон бусад дэд бүтцийн байгууллагууд орно Үйлдвэр нь төвийн эрчим хүчний шугамд холбогдсон 35КВ-ийн 35/6-1600квт-ын өндөр хүчдэлийн дэд станцтай.

## ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт хэрэгжүүлж буй ашиглалтын MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Төмөртэй голын уулын баяжуулах үйлдвэрд” төслийг “Эрдэс групп” ХХК хэрэгжүүлж байна. Тус орд нь 1:100000 масштабтай байр зүйн зургийн М-48-83 тоот хавтгайд 244.74 гектар талбайтай. Төмөртэйн голын төмрийн хүдрийн орд нь 250 м хүртэлх гүнд бодит В зэргээр 13815.85 мян.тн, боломжит С зэргээр 2584.26 мян.тн нийтдээ 16400.1 мян.тн хүдрийн нөөц тогтоогдосноос бодитой нөөц нь ордын хэмжээнд бодогдсон нийт нөөцийн 84.2%, боломжтой нөөц нь 15.75% болно.

Уурхайн олборлолтыг 18 жилийн үйл ажиллагаагаар ашиглах бөгөөд энэ хугацаанд нийт 8.4 сая.м3 уулын ажил хийгдэж, 17.2 сая тонн хүдэр олборлож, 12.26 сая тонн 52.46%-ийн дундаж агуулга бүхий баяжмалыг хуурай соронзон аргаар үйлдвэрлэнэ. Үүнийхээ 8 сая тонныг нь дахин нойтон соронзон аргаар баяжуулж 5.3 сая тонн 66.35%-ийн агуулгатай баяжмал үйлдвэрлэж, Хятад улсын зах зээлд экспортлохоор төлөвлөсөн.

Төмөртэйн төмрийн хүдрийн ордоос жилд 1000 мянган тонн 39.8-47.1%- ийн агуулга бүхий төмрийн хүдэр олборлон хуурай соронзон аргаар баяжуулж, 52.46% агуулга бүхий бүхэллэг баяжмал, мөн үйлдвэрлэсэн бүхэллэг баяжмалаасаа жилд 500 мянган тонныг нь дахин нойтон соронзон аргаар гүнзгий боловсруулж жилд 66.35% агуулга бүхий 332.8мянган тонн баяжмалыг үйлдвэрлэн экспортлох үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийн тодотголын дагуу 2023 онд БОННҮ-г хийж “ЕААС” ХХК гүйцэтгэсэн.

Ил уурхайн ашиглалтын нөөц нь Зүүн, Баруун ил уурхайгаас В+С зэргээр 5446531.1 тн хүдэр олборлоход 4517244.0 м3хөрс хуулалт хийж, 45.9% төмрийн дундаж хүдрийн агуулгатай 2499742.6 тн төмөр олборлоно. Ил аргаар олборлолт явуулахдаа төмрийн хүдрийн Баруун биетээс 1, 2, 3-р жилүүдэд 1558580 м3 хучдас хурдас хуулж гадаад овоолгод, 39600 м3 өнгөн хөрс шимт хөрсний оволгод хурааж, 42.9%-ийн агуулгатай 1109.14 мян.тн хүдэр олборлож, хуурай баяжуулалтын аргаар боловсруулж 52.6%-ийн дундаж агуулга бүхий 475.62 мян.тн эрдэс төмрийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлнэ.

Зүүн биетээс уурхайн олборлолтын 3, 4, 5-р жилүүдэд 119000 м3 хучдас хурдас хуулж гадаад овоолгод, 51000 м3 өнгөн хөрс буюу шимт хөрсний овоолгод хурааж, 47.1%- ийн төмрийн агуулгатай 2400 тн төмрийн хүдэр олборлож, хуурай баяжуулалтын аргаар боловсруулж 52.46%-ийн дундаж агуулга бүхий 1113,6 мян.тн эрдэс төмрийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлнэ. Ил уурхайн хүрээ нь Баруун хүдрийн биет нь 13.2 га талбайд, Зүүн

хүдрийн биетийн 17 га талбайд төмрийн хүдрийн олборлолтыг ил аргаар ашиглалт явуулна. Карьер ашиглалтаас дунджаар Зүүн уурхай 112 м гүнтэй, Баруун уурхай 81.3 м гүнтэй нийт 30.2 га талбайд газрын хэвлийн хоосон орон зай үүссэн. Уурхай ашиглалтын 5 дахь жилээс төслийн хүчин нэмэгдэж жилд 1000 мян. тн хүдэр олборлож 52.46% агуулга бүхий 680 тн -30мм +10мм, -10 мм бүхэллэгтэй, дунджаар 52,46% төмрийн агуулгатай хуурай баяжмалыг үйлдвэрлэх бөгөөд үүний 500 мян.тн хүдрийг нойтон соронзонгийн боловсруулж 66.35%-ийн агуулгатай, 84.18%-ийн металл авалттай 332800 тн төмрийн баяжмалыг фильтр прессийн тусламжтай шүүн хатааж 10%-ийн чийглэгтэй төмрийн баяжмал үйлдвэрлэнэ.

Төмөртэйн голын төмрийн хүдрийн орд нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт Улаанбаатар хотоос хойд зүгт 420 км, Дархан уул аймгаас зүүн зүгт 140 км, Хүдэр сумаас баруун урагшаа 30 км зайд байрлах “Төмөртэй гол” нэртэй ашиглалт явуулах 11426А тоот тусгай зөвшөөрлийн талбайн төв хэсэгт байрлана.

Уг орд нь дэд бүтэц зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн, ундны болон үйлдвэрлэлийн усан хангамж сайтай, цахилгаан эрчим хүчний төвийн шугам сүлжээ сайтай бүс нутагт оршино.

Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж, улмаар 2007 онд хийсэн нарийвчилсан хайгуулын ажлаар ордын хэмжээнд 48,3% төмрийн агуулгатай 16400,1 мян.тн төмрийн хүдрийн нөөц тогтоосон тайланг Үйлдвэр худалдааны Яамны дэргэдэх Эрдэс баялагийн Мэргэжлийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн В зэрэглэлийн 13815,8 мян.тонн, С зэрэглэлийн 2584,3 мян. тонн төмрийн хүдрийн нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн.

## ***ТЕХНОЛОГИЙН ХЭСЭГ***

2023 оны 4-р сараас үйл ажиллагаагаа эхлүүлэхээр батлуулсан хэдий ч эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт санхүүгийн хүндрэлээс шалтгаалан “Төмөртэйн гол” УБҮ бүрэн хүчин чадлаараа төлөвлөсөн хугацаандаа ажиллаж чадаагүй.

2023 онд үйлдвэрийн хүчин чадлаар 20 хоног ажиллаж баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн засвар, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэн 2022 онд олборлосон 89.4 мян.тн хүдрээс 66.2 мян.тн хүдрийг хуурай соронзон сеперацийн аргаар боловсруулж 39.7 мян.тн төмрийн бүхэллэг баяжмал үйлдвэрлэн гаргасан. Тус онд төмөр замын тээврээс шалтгаалан баяжмал борлуулалтын ажил хийгдээгүй болно.

Үйлдвэрийн ажилтан, ажилчдыг Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудаас болон орон нутгийн Хүдэр, Ерөө сумдуудаас сонгон авч, сургаж, дадлагажуулан ажиллуулсан ба нийт давхардсан тоогоор 47 хүн ажилласан.

Ажилчдын амьдарч байгаа орчныг сайжруулах үүднээс ажилчдын байр, хоол цайны газарт засвар, үйлчилгээ хийж, хоолны амт чанар, эрүүл ахуйд байнга хяналт тавьж ажилласан.

*Уурхайн тосгоны зураг:*



## ***БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ БАРИМТЛАХ ЗАРЧИМ***

“Эрдэс групп” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийнбайгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

2023 оны төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

Бид 2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажилласан

- Байгаль орчны удирдлагын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд төслийн үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжих нутгийн экосистемийн бүрэлдэхүүн хэсэг бүрт үзүүлэх байгаль орчны эрсдлүүдийн бүртгэл үнэлгээг хийж, тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний шат дараатай үйл ажиллагааны төлөвлөлт хийн, арга хэмжээг хэрэгжүүлнэ
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулах
- Байгаль орчинд нийлүүлэх хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх,
- Нефтийн бүтээгдэхүүний асгаралт урьдчилан сэргийлж, бохирдсон хөрсийг эрүүлжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлнэ

# БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛ

## 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэс групп” ХХК нь 2023 онд уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаагүй ч байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, цаашид арилгах зорилгын хүрээнд хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулж, байгаль орчныг хамгаалж, ойжуулалт зэрэг ажлуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж 2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан.

Уурхайн БОННҮ-ний тайланд тусгагдсан байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний 2023 оны байгаль хамгаалах төлөвлөгөөг 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилалд заасны дагуу төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бохирдлыг багасгах, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн төлөвлөсөн болно.

Эрдэс групп ХХК 2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт 8 ажил төлөвлөж биелэлтийг ханган ажиллалаа.

***2023 онд Төмөртэй уурхайд хэрэгжүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт***

| № | Байгаль орчны бүрэлдхүүн | Сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил | Биелэлтийн хувь | Гүйцэтгэлийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаар | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын Стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ | Төсөлд хэрэгжүүлэхэд ашиглах бүх дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, машин механизмын тогтмол үзлэг оношлогоонд хамруулах | 100% | Уурхайд ашиглагдаж буй хөдөлгөөнт техникүүдэд 250 км/цаг, 500 км/цаг -дад бүрэн засвар үйлчилгээнд оруулж тос маслыг сольдог. Энэ нь агаарт ялгарах хорт хий, утааг стандарт хэмжээнд байлгах үндэс юм. |
| 2 | | Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас үүсч болох шороо тоосноос агаар тоосжилт үүсэх | Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах | 100% | Уурхайн замын хөдөлгөөний дотоод журмаар хөдөлгөөнт техникийн хурдны хязгаарлалт 40км/цаг хэтрэхгүй байхаар зохицуулсан бөгөөд тэмдэг тэмдэглэгээг дахин шинэчлэн байршуулсан. Уулын ажил явагдаагүй тул усалгаа хийгдээгүй |
| 3 | Усан орчинд нөлөөлөх | Хаягдал усыг зөвшөөрөлгүйгээр зайлуулсны улмаас гадаргын болон газрын доорхи ус бохирдох | Хаягдал ус хаях хэсэгт | | Нойтон баяжуулах үйлдвэр ажиллаагүй хаягдал ус гараагүй болно |
| 4 | Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл | Хаягдал тослох материал ил задгай хадгалснаас асгаралт үүсэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах | Авто засварын талбай | 100% | Авто засварын хаягдал тос цуглуулах, хадгалах талбайг плёнк дэвсэж, хайргаар хучсан |

| № | Байгаль орчны бүрэлдхүүн | Сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил | Биелэлтийн хувь | Гүйцэтгэлийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 5 | | Автомашин, механизмуудыг түлш шатахуунаар цэнэглэх явцад асгаралт үүссэний улмаас хөрс бохирдох | Түлш түр хадгалах, цэнэглэх газар | | Түлш шатахуунаар цэнэглэх талбайг плёнк дэвсэж, хайрган хучилтаар хучсан. |
| 6 | Ургамалан нөмрөг хамгаалах чиглэлээр | Төслийн үйл ажиллагаанаас Ойн бүрхэвч доройтох | Ойжуулалт хийх | 100% | Хүдэр сумын нутагт 5 га талбайд ойжуулалт хийсэн. |
| 7 | Хог хаягдлын менежментийн чиглэлээр | Хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны бохирдол үүсгэх | Төслийн талбайн хог хаягдлыг зөв зохистой зайлуулах арга хэмжээ авах | 100% | Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан. |
| 8 | Амьтан аймгийг хамгаалах чиглэлээр | Нүүдлийн шувууд дайран өнгөрдөг хугацаанд шувуудыг үргээдэг хүчин зүйлүүдэд хяналт тавих | Уулын ажил хийгдээгүй тул шувуудын хувьд таатай нөхцөл бүрдсэн. Тунаах нууранд Ангир, Бор галуу, Нугас зэрэг усны шувууд ирж зуссан. | 100% |   |

## 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус ордод олборлолт явуулж байгаа талбайд хүдрийн биетийн геологийн тогтоц нь босоо учир ил аргаар 100 м хүртэл гүнд ашиглалт явуулж дуусах хүртэлх хугацаанд техннкийн болон биологнйн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй. Харин уг ордыг далд аргаар ашиглаж эхлэх үед тухайн хэсэгт нөхөн сэргээлтнйн ажил хийгдэж эхлэхээр ТЭЗҮ-д тусгагдсан.

1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдахаас өмнө үйл ажиллагааны явцад үүссэн онцгой хамгаалалтын бүсэд байсан объектуудыг татан авч тус бүсэд байсан зам талбайг хэлбэржүүлж 1.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, санхүүжилтийн байдлаас шалтгаалж 2024 онд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, хүлээлгэн өгнө.

***Энгийн хамгаалалттай бүсэд 1,1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал:***





## БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагааны шууд болон дам нөлөөллөөр биологийн олон янз байдалд өртөх эрсдэлээс хамгаалах аргыг тодорхойлохын тулд өртөлтийн судалгааг сайтар хийсэн байх шаардлагатай. Мониторингийн хөтөлбөрөөр экологийн ач холбогдолтой амьтны аймгийн гол хүрээний зүйлүүдийн тооллого, судалгааг дотоод бололцооны дагуу хийж гүйцэтгэх ажлыг хийх бэлтгэл ажил хийгдсэн байгаа.

1. МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас заасан талбайд “Ой Ан Төв” ХХК-тай хамтран Төхөмийн хөндийн тариалангийн 5.1 га талбайд хайлаас модны 2500ш тарьц зурвас суулгасан.
2. 2023 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сөдтэйн гол гэх газарт 5.0 га талбайд 2 наст, нарс модны 10,000 ш суулгацаар ойжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн

***5га талбайд 2 наст нарсны тарьцаар ойжуулалт хийж буй байдал***





***“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний дагуу 5,1 га талбайд хайлаас модны тарьц суулгасан***

| № | Тэгш өнцөгтийн солбицол | | Газарзүйн солбицол | |
|---|---|---|---|---|
| 1 | 673327.863 | 5512840.946 | 107 24 21 | 49 44 35 |
| 2 | 673205.993 | 5513517.088 | 107 24 16 | 49 44 57 |
| 3 | 673043.194 | 5514222.814 | 107  24 09 | 49  45 20 |
| 4 | 673437.354 | 5514420.916 | 107  24 29 | 49 45 26 |
| 5 | 674452.87 | 5514950.541 | 107  25 20,6 | 49  45 42.1 |
| 6 | 675566.76 | 5502019.8 | 107 43 54.7 | 49 38 18.5 |
| 7 | 676459.775 | 5515693.406 | 107 26 17 | 49 45 57 |
| 8 | 676462.425 | 5515683.763 | 107  27 02.1 | 49 45 56.7 |
| 9 | 675571.921 | 551439.359 | 107  26 17.2 | 49 45 56.7 |
| 10 | 674456.947 | 5514941.410 | 107 25 20.8 | 49 45 41.8 |
| 11 | 673442.088 | 5514412.066 | 107 24 29.2 | 49 45 25.7 |
| 12 | 673054.676 | 5514217.710 | 107 24 09.6 | 49 45 19.8 |
| 13 | 673215.749 | 5513519.285 | 107 24 16.5 | 49 44 57.1 |
| 14 | 673337.618 | 5512843.142 | 107 24 21.5 | 49 44 35.1 |





## 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Төмөртэй гол төмрийн хүдрийн орд”-д нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийгдээгүй болно.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сум “Эрдэс Групп” ХХК хооронд “Хамтын ажиллагааны гэрээ”-г 2008 оноос байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2008-2023 оны хооронд тус гэрээний дагуу нийт ***150,242,613.16*** төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна.

## 5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байгалийн өвөрмөц тогтоц бүхий Соронзон хад байдаг бөгөөд уг хад нь ашиглалтын талбайн зүүн хойд талд лицензийн талбайн хилээс 500 м гаруй метр зайд Дархан төмөрлөгийн лицензийн талбайд уулын толгой дээр газарзүйн

$49^{0}\ 41^{I}\ 9.8^{II}$,

$107^{0}\ 14^{I}\ 29.8^{II}$ солбицолд оршдог.

1. Соронзон хадыг үзэхээр орон нутгийн иргэд болон дотоодын аялал жуулчлалаар хүмүүс их ирдэг тул орчны бохирдол үүсдэг. Үүссэн бохирдлыг сард 1-2 удаа цэвэрлэж тохижилт үйлчилгээний ажлыг хийсэн.

2. ЮНЕСКО-ийн конвенцыг мөрдлөг болгон уурхайн орчмын дурсгалт газрууд өнгөрсөн үеийн түүхийн дурсгалууд биет бус соёлын өвийн болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, судлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломж чиглэлийг судлахад анхаарал хандуулан ажиллаж байна.

3. ТЗ-011426 талбайд 2016 онд усан сан бүхий онцгой хамгаалалтын бүс тогтоож, шав тэмдэг газарт бэхлэх ажлыг мэргэжлийн байгууллага болох “Баясах Сүрвэй” ХХК-иар хэмжилт хийлгэн актаар баталгаажуулсан. Тайлант онд нийт 22 шав тэмгийг сэргэээн засварласан.

***Уурхайн ажилчид соронзон хад орчмын цэвэрлэгээ хийж буй байдал***







***22ш Шав тэмдэгийг сэргээн засварласан***

*Өмнө* *Дараа*











*Нийт талбай*



## 6.ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Сургалт явуулах мэдээлэх тогтолцоо*

“Эрдэс Групп” ХХК-ийн асгаралтын журмыг баримтлан уурхайн хэмжээнд асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт болсон тохиолдолд авах хариу арга хэмжээг хүн бүхэн мэддэг байх нөхцөлийг бүрдүүлэх зорилогоор нийт ажилчид болон шинээр ирж байгаа ажилчидад сургалт тогтмол зохион байгуулан ажилласан.

| **1.** | **Сургалт: (давхардсан тоогоор)** | | |
|---|---|---|---|
| *Огноо* | *Удаа* | *Сургалтын нэр* | *Хамрагдсан хүний тоо* |
| *2023-07-20* | *1* | *Шинэ ажилтаны сургалт* | *9* |
| *2023-07-23* | *1* | *Харуул хамгаалалтын албанд ажилтаны ажлын байранд мөрдөх журам* | *3* |
| *2023-09-05* | *1* | *Шинэ ажилтаны сургалт* | *3* |
| *2023-09-07* | *2* | *Хог хаягдлын менежмент* | *22* |
| ***Нийт:*** | ***5*** | | ***37*** |






Сургалт, зааварчилгааны бүртгэлийн хуудас.

Сэдэв: Байгаль орчины менежмент



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Сургалт, зааварчилгааны бүртгэлийн хуудас.

| Огноо | 2022.07.07 | Ээлж | Эхлэх цаг 19:30 | Дуусах цаг 19:50 |
|---|---|---|---|---|
| Төрөл: | Байгаль орчин | | | |
| Сэдэв: | Хог хаягдлын менежмент | | | |
| Сургалт, зааварчилгаа өгсөн: | Мэргэжилтэн Г.Сүхбат | | | |

| № | Овог | Нэр | Регистрийн дугаар | Албан тушаал | Компани | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Сургалт, зааварчилгааны бүртгэлийн хуудас.

| Огноо | 2022.07.09 | Ээлж | Эхлэх цаг 07:45 | Дуусах цаг 08:15 |
|---|---|---|---|---|
| Төрөл: | Байгаль орчин | | | |
| Сэдэв: | Хог хаягдлын менежмент | | | |
| Сургалт, зааварчилгаа өгсөн: | Мэргэжилтэн Г.Сүхбат | | | |

| № | Овог | Нэр | Регистрийн дугаар | Албан тушаал | Компани | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|



Техник хэрэгсэлд ашиглаж буй тос тосолгооны материалд агуулагдаж буй химийн бодис тус бүрийн хольцын найрлага, шинж чанар, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор аюул, нөлөө болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийн самбар байрлуулан мэдээ мэдээллээр хангаж, галын хорны нөөцийг сайтар хангаж ажилласан.

*Галын аюулгүй байдлын самбарууд*






*Ойн түймрээс сэргийлж тосгоны эргэн тойрон хуучин згоныг сэргээн татсан*





УБҮ-ийн засварын ажил эхлэхтэй холбогдуулан ойн түймэр, галын аюулгүй байдлаас сэргийлэн ажилчдын кэмпийг тойруулан татсан згоныг жил бүр сэргээн татаж аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна.

## 6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрдэс групп ХХК-нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Бид 2023 онд хог хаягдлын менежментийг сайжруулах үүднээс ажилчидад сургалтыг тогтмол орж мэдээлэлийг тогтмол өгсөн.

*1. Сургалт:*





*Энгийн хог хаягдлын ангилал:*

Төслийн хэмжээнд гарч буй энгийн хог хаягдлыг дотор нь дахин боловсруулах, дахин ашиглах, лэндфилийн хаягдал гэж 3 ангилан хувааж авч үзсэн.

*Дахин боловсруулах хог хаягдал:*

Уг төрлийн хог хаягдалд бүх төрлийн хуванцар ус, ундааны савнууд болон засварын хэсгээс гарч буй ашигласан тос, маслыг хамааруулан ойлгоно. Эдгээр хаягдлуудыг гэрээний үндсэн дээр дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.

*Дахин ашиглах хог хаягдал:*

Энэ ангилалын хог хаягдалд хаягдал төмөр, дугуй, модон эдлэлийн хаягдал, бүх төрлийн хаягдал цаас, шил, лааз гэх мэт зүйлсийг хамааруулан ойлгоно. Эдгээр хаягдлуудыг ангилал тус бүрээр нь хадгалж дахин ашиглана. Хэрэв төслийн хэмжээнд дахин ашиглах боломжгүй тохиолдолд дараагийн дахин ашиглах байгууллагадшилжүүлнэ.

*Аюултай хог хаягдал:*

Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй хог хаягдал устгах эрхтэй аж ахуйн нэгжид шилжүүлэх гэрээ хийсэн. Техникийн тос материалаар бохирдсон шингээгч материал, алчуур, тосны шүүр, түлш, техникийн тосоор бохирдсон хөрс, химийн бодисын сав баглаа, боодлууд энэ ангилалд багтана.

*Эмнэлгийн хог хаягдал:*

Эмнэлгээс үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношлогооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхит материалыг багтаана.

Манай компаний уурхайн хог хаягдлыг тээвэрлэх зайлуулахтай холбоотой үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий, орон нутгийн компани гардан гүйцэтгэдэг, байгаль орчнымэргэжилтнүүд явцын хяналт, шалгалтыг өдөр бүр хийдэг. Гэрээт гүйцэтгэгч нь дараахь ажлыг гүйцэтгэдэг.

Үүнд:

- Уурхайн хэмжээнд тогтоогдсон бүх хог хаягдлын эх үүсвэрүүд, хог түр хадгалах цэгүүдээстээвэрлэлт хийж зөвшөөрөгдсөн хогын цэгт буулгах
- Эх үүсвэр дээрх ангилан ялгалтыг хянах, мэдээллэх
- Хогын цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах
- Дахин ашиглах эсвэл дахин боловсруулах хаягдлыг ангилах, хуваарилахад туслах

- Устгах, булшлах хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, боловсруулах хаягдлын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Хог хаягдлын өдөр тутмын бүртгэлийг хөтлөх, мэдээлэл гаргаж өгч байна

*Энгийн хог хаягдлын ангилан ялгах*







*Аюултай хог хаягдал хадгалах талбай*









### 2. *Уурхайн хог хаягдлын ангилан ялгалт, 2023 онд гарсан хаягдлын хэмжээ*

| | | Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл | Жилд гарсан нийт хэмжээ | Дахин боловсруулах, үйлдвэрт нийлүүлэх | Хадгалах | Ландфил хийх | Устгал | Иргэдэд олгох | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ахуйн | х | Хуванцар сав | 200 ш | | | | | | Хангамжийн машинд ачиж Дархан-д дахивар хүлээн авах цэгт нийлүүлсэн |
| | | Шил | 90 ш | | | | | | Нутгийн иргэдэд олгож байна |
| | | Лааз | 25 ш | | | | | | Дахивар хураах цэгт хадгалж байна |
| | | Сүү, жүүсний хайрцаг | 40 ш | | | | | | Дахивар хураах цэгт хадгалж байна |
| | | Цаасан хайрцаг | 0.21 тн | | | | | | Нутгийн иргэдэд олгож байна |
| | | Уут шуудай | 40 ш | | | | | | Нутгийн иргэдэд олгож байна |
| | ш | Ахуйн хог хаягдал | 1 тн | | | | | | Ландфил хогийн цэгт устгалд оруулсан |
| | | Хоолны хаягдал | 0,5 тн | | | | | | Гахайн аж ахуй эрхэлж буй иргэнд олгож байна |
| Үйлвэрийн | х | Хаягдал дугуй жижиг | 5ш | | | | | | Хадгалж байна. |
| | | Хаягдал дугуй том | 0,0 ш | | | | | | |
| | | Хаягдал мод | 0,5 тн | | | | | | Нутгийн иргэн зарим ажилчдад олгож байна |
| | | Үнс | 0,0 тн | | | | | | ---------------------------------------------------- |
| | | Гэрлийн шил | 0.09 ш | | | | | | Хадгалж байна |
| | | Төмрийн хаягдал | 0,0 тн | | | | | | Одоогоор борлуулах зорилгоор хурааж байна |
| | | Бохир ус | | | | | | | Саарал усыг жорлонд хийнэ |
| | ш | Аккумлятор | 0,0 ш | | | | | | Хураан хадгалж байна |
| Аюултай хорттой (шингэн-ш, хатуу-х) | х | Тостой даавуу | 0,5тн | | | | | | Шатааж устгалд оруулж байна |
| | | Тостой торх, сав | 0,0 ш | | | | | | Хураан хадгалж байна, мөн борлуулах |
| | | Тосны хаягдал фильтр | 0,0 ш | | | | | | “Хай Би Ойл” ХХК-д нийлүүлэх гэрээтэй |
| | | Химийн бодис /угаалагын бодис/ материал сав | 10 ш | | | | | | Хураан хадгалж байна |
| | | Хаягдал тос | 0,0тн | | | | | | “Хай Би Ойл” ХХК нийлүүлэх гэрээтэй |
| | ш | | | | | | | | |
| Нийт | | | тн | | | | | | |

| № | Төлөвлөсөн ажил | Биелэлтийн шалгуур | Гүйцэтгэлийн тайлбар | Зураган тайлбар |
|---|---|---|---|---|
| 3 | Дахин ашиглагдах хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх | 100% | Гал тогооны хэрэгцээнд ашигласан даршилсан ногооны шилнүүдийг дахивар хадгалах хэсэгт цуглуулж орон нутгийн иргэдэд нийлүүлсэн |  |
| 4 | Орон нутгийн компаниар хог хаягдал тээвэрлэх, цуглуулах үйл ажиллагааг гүйцэтгүүлэх | 100% | Хүдэр сумын тохижилт ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан. |  |
| 5 | Дахивар худалдан авдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах | 100% | Хаягдал тос, эмнэлэгийн хог хаягдал аюултай хог хаягдлын гэрээг эрх бүхий аж ахуй нэгж байгууллагуудтай хийн ажилласан | |
| 6 | Бүх нийтийн цэвэрлэгээ 1-2 удаа | 100% | УБҮ-ийн засварын ажил эхлэхтэй зэрэгцэн цэвэрлэгээний ажлыг нийт ажилчдтай хамтран захион байгуулж хог хаягдлын цэгт төвлөрүүлсэн. |  |

- Энгийн хамгаалалтын бүсэд байгуулсан засварын түр хэсгийг нүүлгэн шилжүүлэх, хог хаягдал болон шатах тослох материалын үлдэгдлийг цэвэрлэх ажлуудыг зохион байгуулсан.

*Өмнө* *Дараа*









## 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний зорилго, ач холбогдол нь хүрээлэн буй орчинд эерэг эсвэл сөрөг өөрчлөлт явагдаж байгааг таньж мэдэхэд оршино. Хяналт шинжилгээгээр цуглуулсан мэдээ нь агаар дахь бохирдуулагчийн төлөв, зүй тогтлыг судлахад ихээхэн ач холбогдолтой.

Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн мэргэжилтэнгүүд уурхай дээр 9 сард ирж ажилласан.

***Мэргэжлийн байгууллагын ирж ажилласан үеийн зураг***





### *Агаарын чанар*

Уурхайн тоосонцорын мониторингийн тогтолцоог төрийн захиргааны байгууллагад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд барихыг зорьж байна. Тус зорилгод хүрэхийн тулд хэмжилтийн шууд аргачлалыг сонгож, хэд хэдэн байршлууд дээр хэмжилт хийсэн.

*Агаарын чанарын хяналт шинжилгээний ажил:*

| д/д | Тодорхойлох үзүүлэлт | Хэмжилт хийх арга |
|---|---|---|
| 1 | Хүхэрлэг хий ($SO_2$) | 20 минут, нойтон химийн аргаар |
| | | 24 цаг, нойтон химийн аргаар |
| | | 20 минут, автомат анализатораар |
| | | 24 цаг, автомат анализатораар |
| 2 | Азотын давхар исэл ($NO_2$), азотын ислүүд ($NO_x$) | 20 минут, нойтон химийн аргаар/ |
| | | 24 цаг,нойтонхимийнаргаар |
| | | 20 минут, автомат анализатораар |
| | | 24 цаг, автомат анализатораар |
| 3 | PM2.5 тоосонцор | 24 цаг, шууд хэмжлийн багажаар |
| | | 24 цаг, автомат анализатораар |
| 4 | PM10 тоосонцор | 24 цаг, шууд хэмжлийн багажаар |
| | | 24 цаг, автомат анализатораар |
| 5 | TSP Нийт тоос | 20 минут, шууд хэмжлийн багажаар |
| | | 24 цаг, их эзлэхүүний аргаар |
| | | 24 цаг, бага эзлэхүүний аргаар |
| | | 24 цаг, шууд хэмжлийн багажаар |
| | | 24 цаг, автомат анализатораар |
| 6 | Мөнгөн ус(Hg) | 20 минут,шууд хэмжлийн багажаар |
| | | 24 цаг, шууд хэмжлийн багажаар |
| 7 | Хүнд металл тодорхойлох 1 сорьц задлах | Атом шингээлтийн спектрофотометр |
| 8 | Хүнд металл(1элемент) | Рентген флюресценцийн аргаар |
| | | Атом шингээлтийн спектрофотометр |
| 9 | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | 20 минут, автомат анализатораар |
| | | 1 цаг, автомат анализатораар |
| | | 8 цаг,автомат анализатораар |
| 10 | Озон ($O_3$) | 8 цаг,автомат анализатораар |
| 11 | CO, $NO_x$, $SO_2$, PM2.5, PM10-ийг тодорхойлох,цаг уурын үзүүлэлтүүдийг хэмжих | 20 минут, автомат анализатораар |
| | | 24 цаг, автомат анализатораар |

### *Усны мониторинг*

Усны мониторингийн хөтөлбөрөөр үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаанаас газрын доорх усны горим, усны чанар, гидрогеохимийн найрлагад учруулж байгаа нөлөөлөл, өөрчлөлтийн хэмжээг тогтоохыг зорьж шинжилгээ хяналтын ажлыг тогмолжуулж эхэлсэн

*Ус ашиглалтын мэдээ, тайлан*

Уурхайн хэмжээнд ус хэрэглэгч тус бүр авсан усны хэмжээгээ нарийн, зөв тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Усны бүртгэл хөтлөх, тайлагнах” гүйцэтгэх захиралын тушаалаар албан бланктай болсон.

*Газрын доорхи усны мониторинг*

Ажиглалтын цооног байгуулж хэмжилт хийх шаардлагаар хуучин гар худгийг ашиглаж байгаа.

*Гадаргын усны мониторинг*

Гадаргын ус нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хамгийн ихээр өртөгдөж бохирлогдож байдаг. Иймд гадаргын усны цэврийн ангилалыг дэлхийн улс орнууд боловсруулан эмиссийн стандарт (ISO) болон чанарын стандарт (MNS)-уудыг гаргаж түүнийгмөрдөж ажиллахыг үүрэг болгодог нь байгаль хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг хангах нэгэн арга зам юм. Нөгөө талаас газрын гүнд хадгалагдаж байдаг хүнд металлууд (Fe, As) уурхайн хөрс, болон шүүрлийн усанд илэрч болзошгүй бөгөөд ямар нэгэн арга хэмжээ авч, цэвэршүүлэх, тунгаах аргуудыг ашиглахгүй бол хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйл, хүний эрүүл мэндэд сөргөөр урт хугацаанд хортой нөлөө үзүүлнэ.

*Усны эрүүл ахуйн үзүүлэлт, бохирдлын судалгаа*

Усны эрүүл ахуйн шаардлагын үүднээс микробиологийн гол үзүүлэлтүүдийг (нянгийн нийт тоо, колиформ, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч) Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-ын лабораторийн мэргэжилтэнгүүд уурхайн бүсэд ирж шинжилгээ авсан.

*Усны чанарын хяналт шинжилгээний ажил*

| д/д | Тодорхойлох үзүүлэлт | Хэмжилт хийх арга |
|---|---|---|
| 1 | Усны орчин(pH) | Шууд хэмжлийн зөөврийн багажаар |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар (EC/ | Шууд хэмжлийн багажаар |
| 3 | Булингаршил | Шууд хэмжлийн багажаар |
| 4 | Жинлэгдэх бодис | Жингийн арга |
| 5 | Уусcан хүчилтөрөгч(O2) | Шууд хэмжлийн багажаар |
| 6 | Уусcан хүчилтөрөгч(O2) | Иодометрийн арга |
| 7 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч(БХХ5) | Титрийн арга |
| 8 | Перманганатын исэлдэх чанар (ПИЧ) | Хүчиллэг орчинд тодорхойлох арга |
| 9 | Хатуулаг | Комплексонометрийн арга |
| 10 | Кальци ($Ca^{2+}$) | Комплексонометрийн арга |
| 11 | Магни ($Mg^{2+}$) | Тооцооны арга |
| 12 | Натри+Кали ($Na^{+}$+$K^{+}$) | Тооцооны арга |
| 13 | Гидрокарбонат ($HCO_3^{-}$) | Потенциометрийн арга |
| 14 | Хлорид($Cl^{-}$) | Аргентометрийн арга |
| 15 | Сульфат ($SO_4^{2-}$) | Турбидиметрийн арга |
| 16 | Эрдэсжилт | Тооцооны арга |
| 17 | Аммонийн азот (NH4-N) | Несслерийн арга |
| 18 | Нитритийн азот (NO2-N) | Гриссын арга |
| 19 | Нитратийн азот (NO3-N) | Салицилатын арга |
| 20 | Фосфат (PO4-P) | Фотоколориметрийн арга |
| 21 | Цахиур (Si) | Фотоколориметрийн арга |
| 22 | Төмөр (Fe) | Спектрофотометрийн арга |
| 23 | Фтор (F) | Фотоколориметрийн арга |
| 24 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч(ХХХ) | Эзлэхүүний арга |
| 25 | Хром (CrVI) | Фотометрийн арга |
| 26 | Гадаргуугийн идэвхт нийлэг бодис (ГИНБ) | Метилен хөхийн оролцоотойгоор тодорхойлох спектрофотометрийн арга |
| 27 | Нефтийн бүтээгдхүүн | Жингийн арга |
| 28 | Нефтийн бүтээгдхүүн | Спектрофотометрийн арга |
| 29 | Къелдалийн азот (Kj-N) | Селений оролцоотой эрдэсжүүлсэний дараа тодорхойлох арга |
| 30 | Сульфат ($SO_4^{2-}$) | Жингийн арга |
| 31 | Хүнд металл тодорхойлох сорьц бэлтгэх | Атом шингээлтийн спектрофотометрийн арга |
| 32 | Хүнд металл (1 элемент) | Атом шингээлтийн спектрофотометрийн арга |
| 33 | Анион (1анион) | Ион хроматографаар |
| 34 | Катион (1 катион) | Ион хроматографаар |
| 35 | Мөнгөн ус (Hg) | Зөөврийн багажаар |
| 36 | Мөнгөн ус (Hg) | Хүйтэн уурын аргаар |
| 37 | Нийт нянгийн тоо | Тарьж өсгөвөрлөх арга |
| 38 | Гэдэсний бүлгийн бичил биетэн | Тарьж өсгөвөрлөх арга |
| 39 | Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн тоо | Тарьж өсгөвөрлөх арга |
Шинжилгээ хийсэн БОШЛ-н инженер М.Өнөржаргал
Шинжилгээг хянасан: БОШЛ-эрхлэгч М.Аягүл

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08-01 УИТ0109

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

0001

БАТЛАВ:
“ХАЙ БИ ОЙЛ “ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ө.ХҮДРЭЭ

БАТЛАВ:
“Эрдэс Холдинг” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

/ Д. Наранзүнс /

# ХАЯГДАЛ ТОС БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2013 оны 12-р сарын 04-ны өдөр № __ Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай **“Хай Би Ойл” ХК-** г төлөөлж Менежер ажилтай Д.Тогосбаатар , нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2655772 регистрийн, 9011031116 тоот улсын бүртгэлийн дугаартай “ Эрдэс Холдинг ” **ХХК-** г төлөөлж Байгаль орчин ажилтай С. Алтантуул нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний **/243-261, 476-480-р/** хуулийн холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр “Хай Би Ойл” ХК болон “Эрдэс Холдинг” ХХК-д гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид ”АХХ” гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, түүнд тохирох үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.

1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

1.4 Талууд гэрээний заалтуудыг тодорхойлоход оролцсон бөгөөд аливаа заалтын хоёрдмол утгатай нөхцөл, тайлбар болон аливаа заалтыг бэлтгэснийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн харгалзан аль нэг талын ашиг тусын тулд эсвэл аль нэг талын эсрэг шийдвэрлэж болохгүй.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл” ХК болон “Эрдэс Холдинг” ХХК-ын гарын үсгүүд зурагдснаар хүчин төгөлдөр болох бөгөөд аль нэг тал дор дурьдсан заалтуудын дагуу энэхүү гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

2.2 Гэрээнд оролцогч талууд нь Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчилэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.

2.3 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.

3.2 Талууд АХХ-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг "Эрдэс Холдинг" ХХК ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.4 "Хай Би Ойл" ХК нь "Эрдэс Холдинг" ХХК-ийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар бэлтгэн нийлүүлэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.

3.5 "Эрдэс Холдинг" ХХК нь АХХ-н тээвэрлэлт, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, бүрэн зориулалтын техникээр тээвэрлэн "Хай Би Ойл" ХК-ийн үйлдвэрлэлийн талбай дээрх цуглуулгын цэг рүү тээвэрлэх үүрэгтэй.

3.6 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд хүлээн авагч тал хүлээн авсан нөхцөлд түүнийг өгсөнд тооцно. Биечлэн хүргүүлсэн аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэж санхүүгийн анхан шатны баримт үйлдэн баталгаажуулах үүрэгтэй.

3.7 "Хай Би Ойл" ХК нь бэлтгэн нийлүүлэгчийн тээвэрлэн ирсэн АХХ-ыг энэ гэрээнд заасан үзүүлэлтүүдтэй тохирох эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр авах боломжтой эсхүл боломжгүй эсэхийг тогтоон хорогдол тооцон авах эрхтэй.

3.8 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

## ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАЛТ БОЛОН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ

4.1 "Эрдэс Холдинг" ХХК-ийн бэлтгэн нийлүүлж буй шаардлагыг хангасан АХХ-н нэг тонн тутмыг 200'000 (хоёр зуун мянга) төгрөгөөр худалдан авах ба талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтнуудын гарын үсгүүдээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтад бичигдсэн хэмжээг үндэслэн тооцно.

4.2 АХХ-н бэлтгэн нийлүүлэлтийн тооцоог 15 хоног тутамд нийлж, төлбөрийг "Эрдэс групп" ХХК Хаан банкны 5003775548 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

## ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан эсхүл нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй эсхүл үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.

5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүйтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал,

ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.

5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

6.3 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.

7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| "ХАЙ БИ ОЙЛ " ХК-ийн | "Эрдэс Холдинг" ХХК-ИЙН |
| Менежер Д.Тогосбаатар | Байгаль орчин |
| ___ | С. Алтантуул — ___ |
| /гарын үсэг/ | /гарын үсэг/ |

## ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

| | |
|---|---|
| УБ хот, СБДүүрэг, 8-р хороо, | Чингисийн өргөн чөлөө-15 |
| Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр, 407 тоот | 1-р хороо, СБДүүрэг, УБ хот |
| Утас: (976)-7011-2205 | Утас: 11-331107 |
| Гар утас: 9909 8989, 9990 4082 | Гар утас: 96682000, 99921937 |
| И-майл хаяг: togosbaatar@hboil.mn | И-майл хаяг: aetantuuls@yahoo.com |

Батлав: Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын

Захирал: ............/Ж.Оджаргал/

Батлав: “Эрдэс групп” ХХК-ийн

Төслийн менежер: ............/Ч.Ариунболд/

**ЭМНЭЛЭГИЙН АЮУЛТАЙ БОЛОН ЭРСДЭЛТЭЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ, ХАЛВАРГҮЙЖҮҮЛЭХ, УСТГАХ АЮУЛГҮЙ БОЛГОХ ГЭРЭЭ**

2023 оны 6 дугаар сар 1 өдөр № Булагтай

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГазрийн захирал ажилтай Ж.Оджаргал, нөгөө талаас “Эрдэс групп” ХХК-ийн төслийн менежер Ч.Ариунболд нар тохиролцож МУ-ын иргэний хууль, Ахуйн болон Үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А/505 тоот тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах , тээвэрлэх, боловсруулах, устгах заавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү гэрээг 2023 оны 06 дугээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 11-р сарын 31-ний өдөр хүртлэх хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд аюултай хог хаягдлыг хадгалах, түр хадгалах байрнаас хогийн цэг хүртэл тээвэрлэх, устгах, харилцагч тал нь гэрээнд заасан хугацаанд аюултай хаягдлыг ангилах,аюулгүй байдлыг хангаж тээвэрлэхтөлбөр төлөх, байгуулага хоорондын ажлын уялдааг сайжируулж хаиуцлагыг дээшлүүлэхэд оршино.

## ГУРАВ. ХАРИЛЦАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

3.2 Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А/505 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллана

3.3 Эмнэлэгээс үүсч буй аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч тал өөрийн байгуулсан зориулалтын устгалын цэгт устгах, аюулгүй болгох үүрэг хүлээнэ.

3.4 Эмнэлэгээс үүсч буй аюултай хог хаягдлыг зөв ангилж цуглуулан аюулгүй байдлыг хангаж тээвэрлэх

3.5 Шингэн нэвчдэггүй бат бөх шар энгийн уутанд аюултай хог хаягдлыг хийж био аюултай тэмдэглэгээ бүхий гурвалжин тэмдэгийг хогны уутны гадна талд зааврын дагуу байрлуулна.

3.6 Халдвартай болон хурц үзүүртэй иртэй хог хаягдлыг аюулгүйн хайрцагт дээд түвшинг 3хэтрүүлээгүй байна.

3.7 Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал үүсгэсний төлбөрөө улирал бүрийн сүүлийн 25-ны дотор Хүдэр тохижилт ОНӨААТҮГазрын 1514000135150 тоот дансанд төвлөрүүлсэн байх

**ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1 Харилцигч талын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

4.2 Хог хаягдлын устгалын хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах

4.3 Хүлээн авах хог хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой байхыг шаардах

**ТАВ. ТЭЭВЭРЛЭХ АЧААНЫ ХЭМЖЭЭ, ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР**

5.1 Үйлчилгээний төлбөрийн тарифийг нэг удаадаа .......................... төгрөг, хаягдлыг хүлээлгэн өгөх цаг хугацааны график нь сард 2-оос доошгүй удаа тушаана.

5.2 Үйлчилгээний төлбөрийг хог хаягдлыг тушаах бүрт тооцож, төлбөрийг Хүдэр тохижолт ОНӨААТҮГазрын 1514000135150 тоот дансанд төвлөрүүлнэ

**ЗУРГАА. БУСАД**

6.1 Талууд энэхүү гэрээг баримталж үйл ажиллагаагаа явуулна.

6.2 Гэрээнд заасан болон бусад зүйлийн талаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүрт шийдвэрлэнэ.

6.3 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын | “Эрдэс групп” ХХК-ийн |
| захирал............/Ж.Оджаргал/ | Төслийн менежер: ............/Ч.Ариунболд/ |
| УТАС: 99373326 | УТАС: 99176824 |

Батлав: Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын
Захирал ................ /Ж.Оджаргал/

Батлав
Дарга : ................ / .Ч.Ариунболд /

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2023 оны 6 дугаар сар 01 өдөр №  Булагтай

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 9.2, 20.1, 20.2, Хүдэр сумын ИТХурлын 2011 оны 06 сарын 09-ний өдрийн 16 тоот тогтоолыг үндэслэв.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

Хог хаягдлаас үүсэлтэй хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон эмнэлэгээс үүсч буй аюултай, үйлдвэрийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон устгах, аюулгүй болгох орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**ГУРАВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ТАЛУУД**

Нэг талаас Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГазрийн дарга ажилтай Ж.Оджаргал, нөгөө талаас Эрдэс холдинг ХК-ны захирал тохиролцож 2023 оны 06 дугээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртлэх хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

**ДӨРӨВ:ТӨЛБӨР ТООЦСОН БАЙДАЛ**

Хүдэр сумын ИТХурлын 2018 оны 06 сарын 06-ний өдрийн 82 тоот тогтоолыг үндэслэн хавсралтад заасан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа чиглэлийн дагуу сарын төлбөрийг тооцож ..............100.000..... төгрөг, жилийн ............500.000............ төгрөгийг Хүдэр тохижолт ОНӨААТҮГазрын 151400135150 тоот дансанд төвлөрүүлэх.

**ТАВ. СУМЫН ЗДТГ-ЫН ЭРХ**

5.1 Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах

5.2 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал гаргасаны төлбөрийг төвлөрүүлэх

5.3 Иргэд, аж ахуйн нэгж байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих

5.4 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

**ЗУРГАА. ААНЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

6.1 Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн болон бусад хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх

6.2 Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал үүсгэсэний төлбөрөө улирал бүрийн сүүлийн 25-ны дотор Хүдэр тохижилт ОНӨААТҮГазрын 151400135150 тоот дансанд төвлөрүүлсэн байх

6.3 Хог хаягдлыг ангилан ялгаж байх

6.4 Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тухай бүрт цэвэрлэж тээвэрэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандарт шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаях

6.5 Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хогдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын ЗДТГазрын хариуцсан мэргэжилтэнд мэдээлж байх

6.6 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах

6.7 Оршин суугаа газрын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох

6.8 Холбогдох хууль, дүрэм журамд заасны дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах

## ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

7.1 Аж ахй нэгж байгууллага нь хог хаягдал үүсгэсний төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагтай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

7.2 Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүрт шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын | |
| Нягтлан ........../Т.Нямгэрэл/ | Захирал .............. / ..Ч.Ариунболд../ |
| УТАС: 96444494 | УТАС: 99176824 |

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХҮЛЭЭЖ АВСАН АКТ

2022 оны 10 сарын 27 ны өдөр          Дугаар .......          *Хүдэр сум*

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын захирамжаар томилогдсон Ойжуулалт, нөхөн сэргээлт хүлээж авах комисс 2022 оны ойжуулалтын ажлыг шалгаж...Эрдэс Групп ХХК.................. /иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/-ын гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын хэмжээ, чанар, үр дүнг газар дээр нь шалгаж үзэхэд:

Хүдэр сумын ...Тохойтын хөндий...газрын....67....р хэсэглэлийн...5.....га талбайд 2013......оны 10...сарын 22...өдрөөс 10......сарын 05.....өдрийн хооронд ......хайлаас модны суулгацаар гар аргаар.................. ................царигдан тарив...........................................

*/модны төрөл, суулгац материалын ялгаа, төрөл, технологийн ялгаа, гар, механикжсан г.м,тарилтын схем/*

Нэг га талбайд /тарьц суулгацын тоо үрийн жин, хэмжээ/ ...2000.......хэмжээгээр анх тарьж суулгаснаас хойш ............оны .........-р. сарын ...........ны өдрийн намрын тооллогоор 1 га-д .........ширхэг, нийт талбайд ............ширхэг таримал мод ургасан байв.Таримлын жилийн өсөлт........см, ерөнхий байдал .......................байв./хэвийн, хэвийн бус гэдгийг бичих/

Харуул хамгаалалтын шийдвэрлэсэн байдлыг тайлбарлан бичнэ:..........................................................................................................................

**Ойжуулалтын ажлын жишиг талбарт явуулсан тооллогын хүснэгт:**

| Жишиг талбайн дугаар | Жишиг талбайн хэмжээ /м²/ | Анх тарьсан тоо/шир/ | Ургаж байгаа модны тоо/шир/ | Хорогдсон модны тоо/шир/ | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өвчин хортоноос | Мал амьтан идсэн | Технологи хангаагүй | Цаг уурын онцгой шалтгаанаар |
| I Талбай | | | | | | | | |
| II Талбай | | | | | | | | |
| III Талбай | | | | | | | | |
| IY Талбай | | | | | | | | |
| Y Талбай гэх мэт..... | | | | | | | | |
| -Бүх жишиг талбайн хэмжээгээр | | | | | | | | |
| -Нэг га-д шилжүүлснээр | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт талбайдшилжүүлснэ эр | | | | | | | | |

Тооллогын хүснэгтээр амьдралт .................. хувьтай ургасан байна.

Ойжуулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийнтайлан мэдээ, газар дээр нь явуулсан тооллого судалгааг үндэслэн комиссоос **ТОГТООХ НЬ:**

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ....................................................../иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/-ын/ийн ................онд гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын хэмжээ нийт ..........га, эхний жилдээ 1 га-д.. ............ ширхэг, нийт талбайд .............ширхэг таримал мод ургасан болохыг тогтоов. Гүйцэтгэлийн хэмжээ чанар, үр дүнгийн байдлыг үндэслэн ойжуулах ажилд зарцуулсан хөрөнгө санхүүжилтийг .......................................эх үүсвэрээс гарган .............хувиар буюу .............мянган төгрөгөөр олговол зохихоос урьдчилгаагаар олгосон ................... мянган төгрөгийг хасч эцсийн санхүүжилтийг ............... мянган төгрөгөөр хийхийг зүйтэй гэж үзэв.

Комиссоос өгөх зөвлөмж:.........................................................................................................

.........................................................................................................................................

Тайлбар: *Ойжуулалтын ажлын хэмжээ өмнө мэдээлснээс дутсан, чанар амьдралтаар норматив хэмжээнд хүрээгүй нөхцөлд гаргасан зардлыг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх хариуцлага тооцох тухай комиссоос дүгнэлт өгнө.*

**АКТ ТОГТООСОН:**

КОМИССЫН ДАРГА ......................................./Д.Мөнхзаяа/

/гарын үсэг, тамга/

ГИШҮҮД......Мишээмаргад......../

......Б. Баярхүү........../

......Б.Батсүх........../

......................................../

......................................../

Зөвшөөрсөн /гүйцэтгэгч/:......Эрдэс Групп......... ХХК-ны ......Ерөнхий инженер......

Р.Ганцэцэг ............................................/

/гарын үсэг, тамга/

13220100002 СТС3006 9055339

ЭРДЭС ГРУПП ХХК-ИЙН ... СЭЛЭНГЭ АЙМАГ

**"Эрдэс Групп" ХХК-ний 2023 оны БОМТ-ний дагуу тарьц тарьж, ойжуулалт хийсэн талбайг хүлээлцсэн тухай акт.**

Сэлэнгэ аймгийн Ойн мэргэжлийн байгууллага "Ой Ан Төв" ХХК-ний инженер ажилчид 2023 оны 10-р сарын 22-ноос 10-р сарын 25-нд "Эрдэс Групп" ХХК-ний 2023 оны БОМТ-ний төлөвлөлтийн дагуу "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн" хөтөлбөрийн 5 га, Дуйцүүлэн хамгаалах 5 га талбайд тарьц тарьж ойжуулах гэрээний дагуу тус компанийн 100 хувийн хөрөнгөөр Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт, Хүдэр сумын Ойн ангийн төлөвлөж заасан газарт:

1. "Хурнайт Хүдэр" ХХК-ний тариалангийн талбайн зурвас Төхөмийн хөндий гэх нэршилтэй газарт Хайлаас модны тарьц 2500 ш буюу 5 га талбайд.

2. Сөдтэйн гол гэх нэршилтэй газарт нарс модны тарьц 10000 ш буюу 5 га талбайд.

Тарьц тарьж ойжуулалт хийснийг газар дээр нь хүлээлцэн акт үйлдэв.

**<u>Тарьц тарьсан талбайн солбицол</u>**

| | д/д | Өргөрөг | Уртраг | X | У |
|---|---|---|---|---|---|
| 1 | **"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний"-ний хөтөлбөрийн дагуу 5,0 га талбайд тарьц тарьсан талбайн солбицол** | | | | |
| | 1 | $49^0 44^I 35^{II}$ | $107^0 24^I 21^{II}$ | 673327.863 | 5512840.946 |
| | 2 | $49^0 44^I 57^{II}$ | $107^0 24^I 16^{II}$ | 673205.993 | 5513517.088 |
| | 3 | $49^0 45^I 20^{II}$ | $107^0 24^I 09^{II}$ | 673043.194 | 5514222.814 |
| | 4 | $49^0 45^I 26^{II}$ | $107^0 24^I 29^{II}$ | 673437.354 | 5514420.916 |
| | 5 | $49^0 45^I 42.1^{II}$ | $107^0 25^I 20.6^{II}$ | 674452.87 | 5514950.541 |
| | 6 | $49^0 46^I 04^{II}$ | $107^0 27^I 02^{II}$ | 675566.76 | 5515447.924 |
| | 7 | $49^0 45^I 57^{II}$ | $107^0 26^I 17^{II}$ | 676459.775 | 5515693.406 |
| | 8 | $49^0 46^I 03.7^{II}$ | $107^0 27^I 02.1^{II}$ | 676462.425 | 5515683.763 |
| | 9 | $49^0 45^I 56.7^{II}$ | $107^0 26^I 17.2^{II}$ | 675571.921 | 5515439.359 |
| | 10 | $49^0 45^I 41.8^{II}$ | $107^0 25^I 20.8^{II}$ | 674456.947 | 5514941.410 |
| | 11 | $49^0 45^I 25.7^{II}$ | $107^0 24^I 29.2^{II}$ | 673442.088 | 5514412.066 |
| | 12 | $49^0 45^I 19.8^{II}$ | $107^0 24^I 09.6^{II}$ | 673054.676 | 5514217.710 |
| | 13 | $49^0 44^I 57.1^{II}$ | $107^0 24^I 16.5^{II}$ | 673215.749 | 5513519.285 |
| | 14 | $49^0 44^I 35.1^{II}$ | $107^0 24^I 21.5^{II}$ | 673337.618 | 5512843.142 |
| | **5.1 га** | | | | |
| 2 | **Дуйцүүлэн хамгаалах төлөвлөлтийн дагуу 5,0 га талбайд тарьц тарьсан талбайн солбицол** | | | | |
| | 1 | $49^0 42^I 10^{II}$ | $107^0 15^I 06^{II}$ | 662356.237 | 5508018.785 |
| | 2 | $49^0 41^I 54^{II}$ | $107^0 15^I 10.3^{II}$ | 662457.351 | 5507528.235 |
| | 3 | $49^0 41^I 54.3^{II}$ | $107^0 15^I 2.7^{II}$ | 662303.702 | 5507532.546 |
| | 4 | $49^0 42^I 9.9^{II}$ | $107^0 15^I 3.4^{II}$ | 662303.421 | 5508014.728 |
| | **5.0 га** | | | | |

Ойжуулалт хийсэн газрын хэмжилт, зураглал болон баталгаажуулсан фото зураг хавсаргав.

/хүснэгтийн **1**-ийн Хавсралт-1, хүснэгтийн **2**-ын Хавсралт-2/

**Ойжуулалтыг гүйцэтгүүлсэн:**

"Эрдэс Групп" ХХК-ний төслийн менежер . . . . . . . . . . . . . . /Ч.Ариунболд/

**Ойжуулалтын ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн:**

"Ой Ан төв" ХХК-ний захирал . . . . . . . . . . . . . . . . . . . . /Ж.Отгонбаяр/

2023 оны 10-р сарын 25.

**ФОТО зураг.**



GOOGLE EARTH MAPS программын хэмжилтийн зураглал.

Хавсралт-1 /план/




Хавсралт-2 /план/
Tukhum Lake
Төхмийн нуур
IV
I
III
II




Хавсралт-2 /3D/
III
II
I
IV


Хавсралт-2 /план/
IV
I
III
II

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 17 өдөр Дугаар Т/43 Улаанбаатар хот

Техник–эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Т/20-12-04 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Эрдэс групп ХХК-ийн MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т зөвшөөрсүгэй.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /Тодотгол-I/, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архив, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Эрдэс групп ХХК-д даалгасугай.

ДАРГА Х.ХЭРЛЭН

53710342

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН**

# ДҮГНЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 10 № 7/20-13-04 Улаанбаатар хот

*Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол I-ийг хэлэлцсэн тухай*

“Эрдэс групп” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК боловсруулсан Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-д Монгол улсын зөвлөх инженер С.Дэлгэрдалай зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Б.Чинзориг шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн товч тодорхойлолт, геологийн хэсэг, Уул-технологийн хэсэг, Баяжуулалтын технологи, Уурхайн инженерийн хангамж, дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн ажлын технологи, Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ зэрэг 8 бүлэг, Оршил, Дүгнэлт, хавсралт материал бүхий 256 хуудас тайлбар бичиг, 33 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. Төмөртэйн голын ордын MV-011426 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2007 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын 21/01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТХЭГ-ын даргын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 472 дугаар тушаалаар (B+C) зэргээр 48.37%-ийн

төмрийн дундаж агуулгатай 16,400.1 мян.тн төмрийн хүдрийн нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгджээ.

5. Төсөлд ил уурхайн хил хүрээнд 6,852.64 мян.тн хүдэр багтсанаас ашиглалтын үеийн хаягдал 2.4% буюу 165.9 мян.тн, бохирдол 3.6% буюу 249.2 мян.тн байхаар тооцож үйлдвэрлэлийн магадалсан B' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц нийт 6,935.94 мян.тн хүдэр байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 8.06 сая.$м^3$ хөрс хуулалт хийхээр тооцжээ. Энэхүү төсөлд ил уурхайн ашиглалтын эхний 8 жилээр тооцооллыг тусгажээ.

6. Далд уурхайд 8,714.1 мян.тн хүдэр багтсанаас ашиглалтын үеийн хаягдал 5.4% буюу 455.6 мян.тн бохирдол 12.6% буюу 1,053.9 мян.тн байхаар тооцож үйлдвэрлэлийн магадалсан B' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц нийт 8,993.4 мян.тн хүдэр байна. Энэхүү төсөлд далд уурхайн ашиглалтын сүүлийн 9 жилээр тооцооллыг тусгажээ Нийт ордын хэмжээнд 15,929.3 мян.тн хүдэр олборлож жилд 1’000.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 17 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

7. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын хүдрийн биетийн тогтоц, шинж чанар, хучаас хөрсний зузаан, хучаас чулуулгийн физик механик шинж чанар зэргийг харгалзан үзэж ил уурхайд авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем, далд уурхайд давхраар албадан нураах ашиглалтын систем тус тус хэрэглэх нь оновчтой гэж үзжээ.

8. Ил уурхайн өрөмдлөгийн ажилд DC-726B маркийн өрмийн машин 2ш, хөрс хуулалтад болон хүдэр олборлолтод 5.4 $м^3$ утгуурын багтаамжтай CAT-390DL маркийн экскаватор 2 ширхэг, 3.0 $м^3$ утгуурын багтаамжтай Hyundai 500LC-7 маркийн экскаватор 1 ширхэг, хөрс болон хүдэр тээвэрт 57 тн-н даацтай MT-86 маркийн автосамосвал 5 ширхэг, хөрсний овоолгод CAT-D9R маркийн бульдозер 1 ширхэг, хүдэр буулгах талбайд 3.0 $м^3$ утгуурын багтаамжтай LG956L маркийн утгуурт ачигч 1 ширхэг, далд уурхайн шпур өрөмдөх ажилд HT81A маркийн өрмийн машин 2 ширхэг, YT-28 маркийн (перфератор) гар өрмийг 3 ширхэг, HYKD-3A маркийн өрмийн суурин машин 14 ширхэг, хоосон чулуулаг болон хүдэр ухаж ачих ажилд WJ-2 маркийн ачигч машин 3 ширхэг, зөөвөрлөх, тээвэрлэх ажилд UK-20 LP маркийн автосамосвал 8 ширхэг тус тус үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

9. Хүдэр баяжуулах үйлдвэрийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон “Геологийн төв лаборатори” ХХК-ийн туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал нь хуурай баяжуулах үйлдвэр 1,000.0 мян.тн/жил, нойтон баяжуулах үйлдвэр 800 мян.тн/жил тус тус байна.

10. Жил бүр төмрийн хүдрийг хуурай болон нойтон аргаар баяжуулж жилд дунджаар 492.75 мян.тн баяжмал үйлдвэрлэхээр тооцсон байна.

11. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Толгойт дэд станцаас Хүдэр сумыг холбосон 35кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамын 141 дэх анкерны тулгуураас өөрийн үйлдвэр хүртэл 10.2 км урттай 35 кВ-ын агаарын шугамыг барьж байгуулсан. Мөн 1600 кВА бүрэн чадал бүхий 35/6 кВ-ын ерөнхий бууруулах дэд станцыг барьж байгуулан үйлдвэрийн болон бусад цахилгааны хэрэгцээг хангахаар тооцжээ.

12. Уурхайн усан хангамж тус орд нь Ерөө голын сав газарт хамаарна. Ил уурхайд дунджаар 6934.2 $м^3$/хоног ус шүүрч орж ирэх ба үүнийг ЦНС 300-120 маркийн

шахуургийн тусламжтай шилжүүлнэ. Далд уурхайд 104681.88 л/хоног технологийн ус хэрэглэх тооцоо гарсан ба үүнийг шүүрлийн усаар хангахаар тооцоолжээ.

13. Нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээт усны эх үүсвэрийг ордын раойнд хийгдсэн газар доорх усны ерөнхий эрэл, урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд тодорхойлогдсон цооногуудад гүний худаг гарган хангах болон уурхайд орж ирэх шүүрлийн усыг хуримтлуулан ашиглахаар тусгажээ. Баяжуулах үйлдвэрийн нийт хэрэгцээт ус 1549.8 мян.м3/жил, үүнээс эргэлтийн ус нь 83.4% буюу дундажаар 1292.5 мян.м3/жил, нэмэлтээр буюу цэвэр ус нь 16.6 % буюу дундажаар 257.27 мян,м3/жил ус ашиглахаар тусгажээ. Уурхайгаас төмөртэйн уурхайн ачих буулгах өртөө хүртэл 0.7 км хатуу хучилт авто замаар тээвэрлэн төмөр замаар Замын-үүд боомтоор БНХАУ-д экспортлоно.

14. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 2,722.1 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчныг хамгаалах ажилд жилд 30.0 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 1,297.33 сая.төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 677.76 сая.төгрөг, хяналт-шинжилгээний зардалд 237.01 сая.төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

15. Уг төслийг хэрэгжүүлснээр 324-511 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,875.40 мян.төг байхаар байна.

16. Төмөртэйн голын төмрийн хүдрийг ашиглах ил болон далд уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 45.28 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс биет бус хөрөнгө оруулалт 986 сая төгрөг, ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 25.9 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 12.08 тэрбум төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 3.99 тэрбум төгрөг, магадалшгүй ажлын хөрөнгө оруулалт 401.6 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 40.1 тэрбум төгрөг байхаар тооцоолсон байна.

17. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 1,318.48 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 1,643.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 330.23 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 262.28 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 226.79 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 237.93 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 161.60 мян.төг/тн байна.

18. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 226.79 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 78.14 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 35.5 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 3.95 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.

2. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

3. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Б.Чинзориг тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. “Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1”-ийг хүлээн авах;

2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах.

3. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших MV-011426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Төмөртэйн голын төмрийн хүдрийн ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.МӨНХЗОРИГ